

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2021 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Шийдвэрийн Зүйл, заалты	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингү й болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан	
1	2	3	4	5	6
Нэг. Монгол Улсын Шадар сайд					
1.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол					
1.	1.	Нийтлэг журам батлах тухай. 2011.11.09 дугаар 311 2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 8.2.1-д заасны дагуу харьяа байгууллага, аж ахуйн нэгж, өөрийн аппаратад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан.	Төрийн байгууллагуудын Дотоод хяналтын баг 2021 оны төлөвлөгөө гарган баталгаажуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Дотоод хяналт явуулсан ажлын үр дүнд төрийн байгууллагуудын дотоод хяналт сайжирч, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт сайжирч, бичиг баримтын эмх цэгц, албан хэрэг хөтлөлтийн стандарт жигдэрсэн. Мөн шинэчилсэн журмын дагуу төрийн албан хаагчид хувийн хэргээ шинэчлэн бүрдүүлсэн. Байгууллага бүр дотоод хяналтын үйл ажиллагааны тайланг мэдээллийн самбар, цахим хуудсандаа ил тод мэдээлж хэвшсэн. Байгууллагын Дотоод хяналтын баг, Ёс зүйн хороо хамтран байгууллагын албан хаагчдад төрийн албаны тухай хууль, ёс зүйн дүрэм, хувийн хэрэг бүрдүүлэх талаар сургалт зохион байгуулсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
2.	2.	Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2017.02.01 дугаар 46 3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг шинэчлэн боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа батлуулан хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, уг журмын	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аймгийн худалдаа үйлчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам шинэчлэн боловсруулж байгаатай холбогдуулан Бат-Өлзий суманд согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 24 иргэний дунд хэлэлцүүлэг зохион байгуулан санал авч аймгийн Хууль, эрх зүйн хэлтэст саналыг	Бүрэн хэрэгжсэн 100%	

		хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд тус тус үүрэг болгосугай.	хүргүүлсэн. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аймгийн худалдаа, үйлчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам батлах тухай” 2021 оны 04/02 дугаар тогтоол шинэчлэгдсэн гарсантай холбогдуулан 2021 оны 9 дүгээр сард тусгай зөвшөөрөл эзэмшигч 50 иргэнд танилцуулан зөвлөгөө, мэдээлэл өгч дэлгүүрүүдийн мэдээллийн самбар, хуулийн буланд байршуулж, мөрдөж ажиллах талаар зөвлөж өгч ажиллаа. 2021 оны 06 дугаар сарын байдлаар тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан 18 иргэний материалыг хүлээн авч, хянан баталгаажуулж, аймгийн зөвлөлд хүргүүлж, тусгай зөвшөөрлийг олгосон.		
3.	3.	Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай 2017.03.07 дугаар 67 1. Жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх Лхагва гарагийг “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” болгон зарласугай. 2. “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, аврах үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх, таниулах ажил зохион байгуулан жил бүр улс даяар тэмдэглэн өнгөрүүлж байсугай.	Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, таниулах өдрийг иргэдэд цахим сүлжээгээр сурталчилсан. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх шторк, сэрэмжлүүлэг бэлтгэн сумын нэгдсэн групп, Бат-Өлзий-урьдчилан сэргийлэх групп зэргээр сурталчилсан. Шторк, сэрэмжлүүлэг цахим сүлжээгээр нийт 3500 гаруй иргэнд хүрсэн байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
4.	4.	Агаарын хэт халалт, хуурайшилттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2017.07.16 дугаар 205 а/ ой, хээрийн бүсэд аялал, зугаалга зохион байгуулахыг хязгаарлаж, орон нутгийн байгаль хамгаалагч, цагдаагийн алба хаагчдын хамтарсан эргүүл, харуул гарган ой, хээрийн	Түймэрийн аюултай үеүүдэд ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, иргэдэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цахимаар болон цаасаар хүргэж, сурталчилсан. Сурталчилгаанд 2000 гаруй иргэн хамрагдсан. Мөн хөдөөгийн багийн 250 айл өрхөд ой, тал хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх, асаасан гал, нурам, цогоо бүрэн унтрааж байх санамж бичиг,	Бүрэн хэрэгжсэн 100%	

		түймрээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх чиглэлээр хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, бүх шатны Засаг дарга нарт;	сэрэмжлүүлэгийг хийж тараасан. Байгаль хамгаалах нөхөрлөлүүдээс түймэр гаргахгүй байх баталгаа гаргуулж, эргүүл, хяналтын ажлыг сайжруулах үүрэг даалгавар өгч хамтран ажиллаж байна. 2021 онд ой, хээрийн түймэр гараагүй.		
5.	5.	Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2021.01.04 дугаар02 1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 17 дугаар жарны цагагчин үхэр жилийн Цагаан сарын баярыг улсын хэмжээнд нийтээр тэмдэглэхгүй байх нь зүйтэй гэж үзсүгэй. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 17 дугаар жарны цагагчин үхэр жилийн Цагаан сарын баярыг сумын иргэд гэр бүлийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлсэн. Сумын Засаг даргын “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” 2021 оны 02 дугаар сарын 09-ны А/29 дүгээр захирамж гарч, хэрэгжүүлж ажилласан. Суманд 8 цэгт хяналтын пост, хөдөлгөөнт эргүүл тасралтгүй ажиллаж, төрийн албан хаагчид 8 цагаар ээлжлэн ажиллаж, иргэдийн орох, гарах хөдөлгөөнийг зогсоож, хяналт тавин цаг үеийн нөхцөл байдлын мэдээлэл, тайланг тухай бүр гарган аймгийн Онцгой байдлын газар, Хархорин сум дахь ОБХэлтэст шуурхай хүргэн ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
6.	6.	Журам батлах тухай 2021.02.21 дугаар 45 1. “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. (Энэ журмын хавсралтыг Засгийн газрын 2021 оны 105 дугаар тогтоолоор өөрчлөн баталсан) 2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын	Суманд 2021 оны 06 дугаар сарын 06-ны өдөр анхны тохиолдол төв аймгийн заамар сумаас зөөвөрлөгдөн ирж бүртгэгдсэн. Түүнээс хойш 2021 оны 12 дугаар сарын 09-ны байдлаар нийт батлагдсан тохолдол 1089 үүнээс нийт эдгэрсэн 1081, нас баралт 6 байна. Нийт өвчлөгсдийн дунд 0-18 насны хүүхэд 265, жирэмсэн 26 байна. Ковид-19 вакцинжуулалтад 2021 оны 12 дугаар сарын 06-ны байдлаар: Жирэмсэн нийт хамрагдвал зохих 78, үүнээс 1 тунд 51, 2 тунд 49, 3 тунд 14 <u>Архаг хүүч өвчтэй хамрагдвал зохих 44</u> Үүнээс: 1тунд 44, 2 тунд 32, 3 тунд 18 <u>ХБИ хамрагдвал зохих 140</u> Үүнээс: 1 тунд 140, 2 тунд 140, 3 тунд 140 <u>65-аас дээш ахмад настан хамрагдвал зохих 153</u> Үүнээс: 1 тунд 153, 2 тунд 143, 3 тунд 80	Хэрэгжих шатанд 70%	

		<p>онцгой комиссын дарга С.Амарсайхан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт үүрэг болгосугай.</p>	<p><u>Албан байгууллага:</u> ЭМТ: 1 тун 35, 2 тун 35, 3 тун 28 ЕБС,СӨББ: 1 тунд 172, 2 тун 172, 3 тун 72 ЗДТГ: 1 тун 34, 2 тун 34, 3 тун 30 ИТХ: 1 тун 3, 2 тун 3, 3 тун 1 Төрийн банк: 1 тун 8, 2 тун 8, 3 тун 6 Хаан банк: 1 тун 5, 2 тун 5, 3 тун 4 Цагдаа: 1 тун 5, 2 тун 5, 3 тун 5 ЭЭС: 1 тун 5, 2 тун 5, 3 тун 4 хүн хамрагдсан мэдээтэй. 2021 оны 11-р сарын 02-ны өдрөөс 2021 оны 11-р сарын 04-ны өдрийг хүртлэх хугацаанд “Нэг өрх-Нэг шинжилгээ”-ний ажлыг сумын Сумын Онцгой комисс, Эрүүл мэндийн төв хамтран зохион байгуулж ажиллаа. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд өдөр бүр холбогдох мэдээ, нэгтгэлүүдийг дээд шатны байгууллагад хүргүүлж ажилласан. Сумын Халдвар, хамгааллын баг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хүнсний дэлгүүр, барааны дэлгүүр, ЭЭСан, цайны газар, ШТСтанцууд, халуун ус, үсчин, бизнес хөгжлийн төв, Хаан банк, Төрийн банк зэрэг нийт 82 объектын 4230 м2 талбайд халдваргүйтгэл хийсэн. Ковидын голомтод ЭМТөвийн хариу арга хэмжээний баг ажиллаж, Сумын Онцгой комисс, ЭМТөвөөс өдөр бүр иргэдэд Facebook группээр зөвлөгөө, мэдээ, мэдээллийг тогтмол өгч байна.</p>		
Дундаж үнэлгээ			95%		
Хоёр. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга					
2.1. Ерөнхийлөгчийн зарлиг					

7.	7.	<p>Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай 2017.07.10 дугаар 186</p> <p>1. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт” дахь газар усны газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, тухайн орон нутагтаа ард иргэдийн дунд сэргээн хэвшүүлэх, цаашид хууль бусаар газар орны нэр өөрчлөх гэмт явдалтай хууль тогтоомжийн дагуу тууштай тэмцэхийг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>2. Уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж занших, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах буюу бусад хэлний дуудлагаар галиглахгүй байхыг Монгол Улсын нийт иргэд, байгууллагад уриалсугай.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт” дахь газар усны газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, таниулах зорилгоор бүх байгууллагуудад албан бичиг хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж занших, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах буюу бусад хэлний дуудлагаар галиглахгүй байхыг албан байгууллагууд болон аж ахуйн нэгж, иргэдэд уриалж, цахим хуудсаар сурталчилсан. Сумын Засаг даргын 2020 оны А/72 дугаар захирамжаар байгуулсан Газар зүйн нэрийн сумын салбар зөвлөл хяналт тавин ажиллаж байна.</p>	Хэрэгжих шатанд 70%	
8.	8.	<p>Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021.10.04 дугаар58</p> <p>2.Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.</p>	<p>Бат-Өлзий сум нь “Тэрбум мод тарих” хөдөлгөөнд нэгдэж, ажлын төлөвлөгөө боловсруулах, нарийвчилсан тооцоолол гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг сумын Засаг даргын 2021 оны 174 дүгээр захирамжаар томилсон. Мод тарих газар нутгийн талбай, хэмжээ, мод тарихад шаардлагатай төсөв санхүүгийн тооцоолол зэргийг гарган холбогдох газарт хүргүүлсэн.</p>	Хэрэгжих шатанд 70%	
2.2 Монгол Улсын Засгийн газрын тогтоол					
9.	9.	<p>Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай 2005.04.01 дугаар 67</p> <p>1.б/. иргэдээс амаар, бичгээр болон цахим сүлжээ, радио, телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр, түүнчлэн тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлын</p>	<p>Төрийн байгууллагууд иргэдийн өргөдөл, гомдол, саналыг хүлээн авах албан хаагчийг томилон ажиллуулж, санал хүсэлтийн хайрцаг, хаяг, цахим хуудасны мэдээллийг нээлттэй байрлуулан ажиллаж байна. Улсын тэргүүний 1 дүгээр цэцэрлэг санал гомдол авах утас /77321551/ утсыг ажиллуулж эхэлсэн. 2021 онд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд бичгээр нийт 586</p>	Бүрэн хэрэгжсэн 100%	

		талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг шалгах, шийдвэрлэлтийн явцыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг нийтэд зарлан сурталчлах зэрэг ажлыг дээрх журамд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авах	өргөдөл ирж холбогдох байгууллага, албан тушаалтнуудад шуурхай хүргэн, 586 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Ирсэн өргөдлийг агуулгаар нь авч үзвэл: Нийгмийн халамжтай холбоотой 251 буюу 43%, Иргэний бүртгэл, мэдээлэлтэй холбоотой 152 буюу 26,0%, Ажилд орох, чөлөөлүүлэх 101 буюу 17%, Тэтгэвэр тогтоолгох 66 буюу 11,2%, Нийгмийн даатгалтай холбоотой /Нас барсан иргэний 1000 000 төгрөгийн батламж авах өргөдөл/ 13 буюу 2,2%, бусад 3 буюу 0.6%-ийг тус тус эзэлж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээллийг сумын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж хэвшсэн.		
	10.	1.в/. иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд тусгагдсан асуудлуудыг өөрийн байгууллагын хэрэгжүүлэх бодлого, авах арга хэмжээнд тусган ажиллах	Тус сумын 1-р багийн иргэдээс Улааны голд гүүр барих асуудлыг удаа дараа уламжлан ирүүлж байсаныг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган 2021 онд орон нутгийн хөгжлийн сангийн 250.0 сая төгрөгөөр Улааны гол дээгүүр бетонон гүүр барьж ашиглалтад оруулсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
	11.	3.Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг ИТХ-д шилжүүлэн шийдвэрлүүлж, дүнг нэгтгэн улирал, хагас, бүтэн жилийн мэдээлэлд оруулж байх	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол ирээгүй. Төрийн байгууллагуудад ирсэн өргөдөл гомдлыг сумын хэмжээнд нэгтгэн холбогдох газарт хугацаанд нь мэдээлж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
10.	12.	Аргачлал шинэчлэн батлах тухай 2018.01.24 дугаар 20 2.Аргачлал батлагдсантай холбогдуулан хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээллийг дараа оны 2 дугаар сард багтаан “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д оруулан баталгаажуулж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, шаардлагатай мэдээллийг бэлдэж 2021 оны 3 дугаар сарын 01-нд “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д баталгаажуулж оруулсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
11.	13.	Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай. 2009.05.14 дугаар 143	Суманд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажил, Төсөв, хөрөнгийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, үйл ажиллагааны мэдээллийг Бат-Өлзий сумын нэгдсэн	Бүрэн хэрэгжсэн 100%	

		2. “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	групп, Batulzii.ov.gov.mn цахим хуудсанд байршуулж, ил тод мэдээлж байна.		
12.	14.	Журам батлах тухай 2017.04.12 дугаар 111 1. “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын хэрэгжилтийг зохион байгуулан мэргэжил, арга зүйн заавар, аргачлалаар хангаж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад, журмыг эрхлэх ажлынхаа хүрээнд үе шаттайгаар нэвтрүүлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	ЗДТГазар, ЕБСургууль Архив, албан хэрэг хөтлөлтийн ORG-RMS программыг суулган нэвтрүүлэн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж байна. 2021 оны захирамжлалын 4 хадгаламжийн нэгжийг скайнардаж PDF файл үүсгэж, цахим архивт шилжүүлсэн. ЗДТГ-ын албан хаагчид баримт бичгийн 3 жилийн мэдээллийн цахим сантай болсон.	Бүрэн хэрэгжсэн 100%	
13.	15.	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 дугаар 258 1.1. Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх;	Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчдийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахад онцгой анхаарч сумын ЗДТГазар, бусад төсвийн байгууллагад орон тооны бус 5 ёс зүйн зөвлөлд 26 төрийн албан хаагч ажиллаж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг бүх ажилтан, албан хаагчдад танилцуулж, баталгаа гаргуулж, дотооддоо ёс зүйн сургалтыг 1-2 удаа зохион байгуулж, байгууллага бүр ёс зүйн хариуцлагыг өндөржүүлэхэд анхаарч ажиллаж байна. 2021 онд ажлын хариуцлага алдсан 1 албан хаагчид цалингийн арга хэмжээ, 3 албан хаагчид сануулах арга хэмжээ тооцсон байна.	Хэрэгжих шатанд 70%	
	16.	1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр	Манай суманд ЗДТГазрын Санхүүгийн албаны төсөв, төрийн сангийн мэргэжилтний 1 сул орон тоо гарсан. Уг орон тооны захиалгыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж, тусгай шалгалт 3 удаа зарлагдсан. Одоогийн байдлаар сул орон тоо журмын дагуу нөхөгдөөгүй байна.	Хэрэгжих шатанд 70%	

	шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;			
17.	1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх;	2021 оны 02 дугаар сард ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасгийн 1 мэргэжилтэн жирэмсэн, амаржсаны амралтаа авч, сул орон тоонд түр томилсон шийдвэр гарсан. Өөр албан тушаалд гэрээт ажилтан томилсон шийдвэр гаргаагүй.	Бүрэн хэрэгжсэн 100%	
18.	1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;	Байгууллагын дотоод журам, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээнд сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулах заалт тусган, төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглох чиглэлээр зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлж, биелэлтийг тооцон ажиллаж байна. Архи, согтууруулах ундаа хэрэглэсэн 3 албан тушаалтанд сахилгын арга хэмжээ тооцсон.	Хэрэгжих шатанд 70%	
19.	1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;	ГХУСАЗ салбар зөвлөл, ЗДТГазар хамтран төрийн албан хаагчдад Төрийн албаны тухай шинэчилсэн хууль, Засгийн газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2017 оны 01 дүгээр албан даалгаварыг хэрэгжүүлэх, Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018 оны 258 дугаар тогтоол, Эрүүгийн хуулийн албан тушаалын гэмт хэргийн хор уршгийн талаар цахим сургалт, сурталчилгаа зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн. Сургалтанд 120 албан хаагч хамрагдсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	

	20.	1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;	Шинэ коронавируст халдвар гарсантай холбогдуулан цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллыг сайжруулах зорилгоор албан хаагчдын цаг бүртгэлийг цаасаар бүртгэж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
	21.	1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;	Төрийн албан хаагчид төрийн бодлого шийдвэрийг иргэдэд хуулийн дагуу түргэн шуурхай хүргэж, ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдэл гаргалгүй ажиллаж байна. Энэ талаар байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
	22.	3. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	2021 оны 02 дугаар сард Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүн сумын ЗДТГазар болон бусад байгууллагыг хамруулан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Зөрчил, дутагдлыг арилгаж, цаашдынхаа ажилд мөрдлөг болгон ажиллаж байна.	Хэрэгжих шатанд 70%	
14.	23.	Дүрэм батлах тухай 2019.01.23 дугаар 33 1. “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай. (Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2019 оны 122 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон) 2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж,	Төрийн байгууллагууд дотоод журмаа энэхүү тогтоолд нийцүүлэн шинэчлэн баталгаажуулж, мөрдөн ажиллаж байгаа. ЗДТГазар, бусад төсвийн байгууллагад орон тооны бус 5 ёс зүйн зөвлөлд 26 төрийн албан хаагч ажиллаж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг бүх ажилтан, албан хаагчдад танилцуулж, баталгаа гаргуулж, дотооддоо ёс зүйн сургалтыг цахимаар 1-2 удаа зохион байгуулж, байгууллага бүр ёс зүйн хариуцлагыг өндөржүүлэхэд анхаарч ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	

		хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	2021 онд ажлын хариуцлага алдсан 1 албан хаагчид цалингийн арга хэмжээ, 3 албан хаагчид сануулах арга хэмжээ тооцсон.		
15.	24.	Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2019.04.17. дугаар 149 3. Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан авах замаар шийдвэрлэх, “Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д зөвлөсүгэй.	Бат-Өлзий суманд ХУР системээс иргэдэд 54 төрлийн лавлагаа, мэдээлэл гаргах боломжтой болсон. 2021 оны хагас жилийн байдлаар 82 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Үүнд: иргэний үнэмлэхний лавлагаа 64, Жолоочийн лавлагаа 25, нийгмийн даатгалын төлөлтийн лавлагаа 15, төрсний бүртгэлийн лавлагаа 5, Гэрэлсний бүртгэл 5, Гэрлэлт бүртгэлгүй 2, үл хөдлөх хөрөнгөтэй эсэх 2, Вакцины лавлагаа 5-ийг гаргаж ажилласан байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
16.	25.	Үндэсний их баяр наадмын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021.07.02 дугаар 183 2. Аймаг, сумдын баяр наадам, хурдан морины уралдаан, уул, овооны тахилга, тэмдэглэлт ой зэрэг нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй байхыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2021 оны сумын баяр наадам, хурдан морины уралдаан, уул, овооны тахилга, тэмдэглэлт ой зэрэг нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулаагүй.	Бүрэн хэрэгжсэн 100%	
17.	26.	Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай 2021.10.13 дугаар 315 3. Аж ахуйн нэгжийн улсын тооллогод өөрийн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах орон тооны бус ажлын хэсэг байгуулж, тооллогын ажилд татан оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч	Сумын Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн а/161 дүгээр захирамжаар суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах орон тооны бус ажлын хэсэг байгуулж, тооллогын ажилд татан оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Тооллогод ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг 100 хувь бүрэн хамруулсан. Тооллогын мэдээ түгээх зардалд 60 000 төгрөг зарцуулсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	

		ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тооллогын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай.			
2.3. Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар					
18.	27.	<p>Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017.10.26 дугаар 01</p> <p>1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагын дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад:</p> <p>1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах.</p>	Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчдийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахад онцгой анхаарч сумын ЗДТГазар, бусад төсвийн байгууллагад орон тооны бус 5 ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг бүх ажилтан, албан хаагчдад танилцуулан, баталгаа гаргуулж, дотооддоо ёс зүйн сургалтыг зохион байгуулж, байгууллага бүр ёс зүйн хариуцлагыг өндөржүүлж ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
	28.	1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх.	Авлигатай тэмцэх, авлигын эсрэг сумын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан сумын Засаг даргаар батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Авлигын эсрэг хуулийг төрийн албан хаагчдад сурталчлан, Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, байгууллагуудын дотоод журамд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр заалт оруулж батлан мөрдүүлж байна. 2021 онд авлигын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагч бүртгэгдээгүй.	Бүрэн хэрэгжсэн 100%	
	29.	1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал	Иргэдээ сонсож, төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд, хүндрэл, чирэгдэлгүй хүргэж ажиллахад анхааран ажиллаж байна. Энэ хугацаанд “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д Бат-Өлзий сумын төрийн албан хаагчидтай холбоотой гомдол, санал ирээгүй.	Бүрэн хэрэгжсэн 100%	

		гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах.			
	30.	1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэн, ажлын байрны дэг журмыг чанд сахих.	Төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын үр дүн, бүтээмж, гүйцэтгэлийн байдалд хяналт, үнэлгээ хийж, дүгнэлт гаргахад ажлын цаг ашиглалт дутагдалтай байсан тул цагийн бүртгэлийг сайжруулах үүрэг чиглэл өгч, хяналттай ажилласны үр дүнд ажлын бүтээмж сайжирсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
	31.	1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.	Төрийн албанд нийт 260 албан хаагч ажиллаж, төрийн бодлогыг хэрэгжүүлэн, тогтвор суурьшилтай, ажлын байранд мэргэжлээ дээшлүүлж, төрийн залгамж чанарыг бэхжүүлэн тасралтгүй ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ЕБСургуулийн мэргэжлийн багшаар 100 хувь хангагдсан. Эрүүл мэндийн төвийн хувьд их эмчийн дутагдалтай байгааг холбогдох газарт уламжлан, аймгийн БОЭТөвийн мэс заслын их эмч 3 сарын хугацаанд ажиллах томилоттой ирж, залуу эмч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дадлагжуулан ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
Дундаж үнэлгээ				92,8%	
Гурав. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд					
3.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг					
19.	32.	Мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2010.04.14 дугаар 63 1. жил бүрийн 5,10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн “Бямба” гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласугай. 2. Мод тарих үндэсний өдөр бүх нийтээр мод, бут, сөөг, цэцэг тарих, цаашид арчлан хамгаалах, түүнийгээ амьдралын хэв маяг болгон хэвшүүлэн сурталчилж ажиллахыг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хандивлагч нарт уриалсугай.	Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтээр “Мод тарих үндэсний” өдрийг угтаж мод бут, сөөг тарьж ургуулах, ногоон байгууламжид тарьсан мод бутыг услах арчлах, хамгаалах, танаж хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж, мод тарих аргачлал зөвлөмжийг 280 иргэнд тарааж, facebook группээр сурталчилсан. 2021 оны 5, 6-р сард мод тарих арга хэмжээнд нийт 10 аж ахуйн нэгж, 315 иргэн оролцож 11 төрлийн 9500 ширхэг мод, бут сөөг тарьж, амьдралт 90%-тай ургасан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
3.2 Монгол Улсын Засгийн газрын тогтоол					

20.	33.	<p>Журам батлах тухай 2009.07.22 дугаар 227</p> <p>2. Ойн сангийн тодорхой хэсгийг энэхүү журмын дагуу нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх замаар ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах ажлын үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон.</p>	<p>Суманд 27 нөхөрлөл ойн санг гэрээгээр эзэмших, орчны бүс болон нийт талбайг хариуцан хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах чиглэлээр ажиллаж байна. Нөхөрлөлүүдийг чадваржуулах, бэхжүүлэх, ойг нөхөн сэргээж, хамгаалах ажлыг сайжруулах тал дээр анхаарал тавьж, Ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын хүрээнд сумын хэмжээнд ойн 14 нөхөрлөлүүд, 10 ААНэгж нийт 30 га талбайд 60000 ширхэг шинэсний тарьцаар ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Улсын төсвөөр 20 га, хувийн хөрөнгө оруулалтаар 10 га талбайд ойжуулалт хийсэн.</p> <p>Үүнд: Бат-Өлзий сумын Хойд агуйтын Сүвээд 30 га талбайд ойжуулалтын ажлыг 100% хийж гүйцэтгэсэн.</p>	Бүрэн хэрэгжсэн 100%	
21.	34.	<p>Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2020.11.18 дугаар 184</p> <p>1. Ойгоос бэлтгэж ашиглах 1 шоо-метр хэрэглээний мод, түлээнд ногдуулах төлбөрийн хэмжээг 1 дүгээр хавсралт, ойд арчилгааны огтлолт хийх болон ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг хөнгөлөх хувь, хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тогтоосугай.</p> <p>2. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>Ойн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглуулах зорилгоор сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн “2021 оны хэрэглээний болон түлшний модны хуваарь батлах тухай” 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 3/15 дугаар тогтоол гарч хэрэгжүүлэн, сумын хэмжээнд 10 ойн мэргэжлийн байгууллага, 25 нөхөрлөлтэй давхардсан тоогоор 63 гэрээ байгуулж, Сумын нийт дүнгээр 299 га талбайд тусгаарлалт хийж, хэрэглээний мод 4461 м3, түлшний мод 4304 м3, байр саравчны зориулалтаар 28 өрхөд 198м³, 1304 өрхөд 7824м³ мод бэлтгэн, орон нутгийн төсөвт 90.0 сая төгрөг оруулахаас жилийн эцсийн байдлаар 112.0 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг давуулан биелүүлсэн.</p>	Бүрэн хэрэгжсэн 100%	
22.	35.	<p>Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай /2016-2030/</p>	<p>Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтээр “Мод тарих үндэсний” өдрийг угтаж мод бут, сөөг тарьж ургуулах, ногоон</p>	Бүрэн хэрэгжсэн 100%	

		<p>2016.01.11 дугаар 35</p> <p>2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусган, олон улсын байгууллага, хандивлагч орон, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	байгууламжид тарьсан мод бутыг услах арчлах, хамгаалах, танаж хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж, мод тарих аргачлал зөвлөмжийг 280 иргэнд тарааж, facebook группээр сурталчилсан. 2021 оны 5, 6-р сард мод тарих арга хэмжээнд нийт 10 аж ахуйн нэгж, 315 иргэн оролцож 11 төрлийн 9500 ширхэг мод, бут сөөг тарьсан.		
23.	36.	<p>Аялал жуулчлалын гол чиглэл батлах тухай 2018.06.13 дугаар 171</p> <p>3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймаг, нийслэлийн аялал жуулчлалын чиглэлүүдийг аялал жуулчлалын гол чиглэлтэй нийцүүлэн баталж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>Бат-Өлзий сумын Аялал жуулчлалын дэд хороог Засаг даргын орлогчоор ахлуулсан нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажилласан.</p> <p>Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын маршрутыг брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор байгалийн аяллын төрлөөр Найман нуур, Улаан цутгалан, Төвхөн хийд чиглэлийн маршруттай болсон. Аялалын маршрутын саналыг аймгийн БОАЖГазарт хүргүүлж, аялал жуулчлалын гол чиглэлийг баталгаажуулсан.</p> <p>Найман нуур-Бөөргийн жуулчны баазын “3 өдөр, 2 шөнийн хөтөлбөр” морин аялалд нийт 1000 гаруй аялагч хамрагдсан.</p> <p>2021 оны 12 дугаар сарын 04, 05-нд "Kharakhorum ice festival-2021" мөсөнд авиралтын цомын аварга шалгаруулах тэмцээн Бат-Өлзий сумын Улаанцутгалантад амжилттай зохиогдож өндөрлөсөн.</p> <p>Экстрим спорт сонирхогчид 2012 оноос эхлэн тус тэмцээнийг зохион байгуулж ирсэн ч сүүлийн хоёр жилд ковидын улмаас тасраад байсан. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, мөсөнд авиралтын шилдэг тамирчдыг төрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой учраас зохион байгуулагч “Монголиа Экспедишнс” ХХК-тай хамтран ажиллаж байна. Энэ удаагийн тэмцээнд 12 байгууллага, клубын 70 тамирчин оролцож, хоёр өдрийн</p>	Бүрэн хэрэгжсэн 100%	

			турш хурд хүч, авхаалж самбаагаа сорин мөсний авиралт хийсэн. Энэхүү тэмцээнийг нийт 500 гаруй хүн ирж үзэж, сонирхсон.		
24.	37.	<p>Журам батлах тухай 2018.12.26 дугаар 391</p> <p>1. “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад, төлбөрийн орлогыг төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p>	Монгол Улсын Засгийн газрын "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 2020 оны 211 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсөвт 8945000 төгрөгийг төвлөрүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%	
3.3 Сайдын тушаал					
25.	38.	<p>Бугын эвэр түүж бэлтгэхийг түр хугацаагаар хориглох тухай 2017.04.20 дугаар А/97</p> <p>2.Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, орон нутагт холбогдох арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, Аймаг нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга, Сав газрын захиргааны дарга, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар /Ч.Батсансар/-т тус тус даалгасугай.</p>	Ой, хээрийн түймэр, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ой, ойт хээрийн бүсэд байгалийн жамаар унасан бугын ясан эвэр түүх үйл ажиллагааг хориглсон тухай мэдээллийг иргэд, олон нийтэд Facebook-ээр мэдээлэл өгсөн. Сурталчилгаанд 1500 гаруй иргэн хамрагдсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
3.4 Сайдын албан даалгавар					
26.	39.	<p>Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай 2015.01.25 дугаар 01</p> <p>Хоёр. Сум, дүүргийн Засаг дарга нарт, аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газруудад:</p>	Хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хяналт, шалгалт 2 удаа зохион байгуулж, 13 зөрчил, 5 гэмт хэрэг илрүүлж, холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж байна. Иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хуулийн сурталчилгаа, зөвлөгөө	Бүрэн хэрэгжсэн 100%	

	1. Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, хяналт, шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулах.	мэдээллийг шуурхай өгч ажиллаа. Сурталчилгаанд 250 иргэн хамрагдлаа.		
40.	2. Сумын төвүүдэд мод, модон материалын төвлөрсөн захыг нээж, ажиллуулах, модны захыг бичлэг хийх боломжтой камераар тоноглож, өөр аймаг, сум руу тээвэрлэгдэж байгаа мод, модон материалыг зөвхөн энэ модны ухаас гаргадаг нөхцөлийг бүрдүүлж ажиллах, ингэснээр мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээг нэг цэгээс олгох үйлчилгээг нэвтрүүлэх.	Модны захын эзэнтэй экологийн хариуцлагын гэрээ байгуулж, мод, модон материал боловсруулах цэгүүдийг камержуулсан. Модны зах дээр бүх нөхөрлөлүүдийн бэлтгэсэн хэрэглээ болон түлээний модыг төвлөрүүлж гарал үүслийн гэрчилгээг олгож, нийт 1414 ширхэг мод, модон материал тээвэрлэх гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
41.	3. Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх чиглэлээр сайн дурын бүлэг байгуулж ажиллуулах асуудлыг дэмжих, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажилд иргэн, нөхөрлөл, ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх	Бат-Өлзий сумын Ойн анги, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нар “Бат-Өлзий орчны бүсийн ойн нөхөрлөлүүд” ТББайгууллагатай хамтран хяналт шалгалтын ажлыг хамтран зохион байгуулж, оролцоог нэмэгдүүлж байна. Ойн мэргэжлийн байгууллага 8, 18 нөхөрлөлийн ахлагч нартай Хууль бус мод бэлтгэх зөрчлийг бууруулах чиглэлээр баталгаа гаргуулан авсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
42.	4. Ойн санг нөхөрлөл, ААН, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх талбайн хэмжээг нэмэгдүүлэх, ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, ААН, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах.	Ойн сангийн 40 хувийг 27 нөхөрлөл, ААН, байгууллагад гэрээгээр эзэмшүүлж, ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, ААН, байгууллагуудын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин, Ойн санг гэрээгээр эзэмших, орчны бүс болон нийт талбайг хариуцан хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах чиглэлээр ажиллаж, Нөхөрлөлүүдийг чадваржуулах, бэхжүүлэх, ойг нөхөн сэргээж, хамгаалах ажлыг сайжруулах тал дээр анхаарч, ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын үр дүнг сайжируулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг байнга өгч ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
43.	5. Ерөнхийлөгчийн 2014 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 48 дугаар Зарлигийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг ойн мэргэжлийн байгууллага, төрийн байгууллага, нөхөрлөл, иргэдтэй хамтарч зохион байгуулан мэдээллийг ил тод болгох арга хэмжээ авах.	Ерөнхийлөгчийн 2014 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 48 дугаар Зарлигийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд 8 аж ахуйн нэгжийн захирал, 18 нөхөрлөлийн ахлагч нартай хууль бус мод бэлтгэлтэй эрчимтэй тэмцэх баталгаа гаргуулж авсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	

	44.	6. ААН, байгууллагын бэлтгэх болон бэлтгэсэн модны хэмжээг ил тод болгох.	Мод бэлтгэлийн мэдээллийг ил тод болгон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, цахим хуудсаар танилцуулж, мэдээллийн самбарт нээлттэй мэдээлдэг.	Бүрэн хэрэгжсэн 100%	
	45.	7. Мод бэлтгэсэн ААН, нөхөрлөлийн өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийсэн байдлыг шалгах, хийгээгүй тохиолдолд нөхөн тариулах, шаардлагатай бол мэргэжлийн байгууллагын эрхийг цуцлах арга хэмжээ авах.	Суманд 27 нөхөрлөл ойн санг гэрээгээр эзэмших, орчны бүс болон нийт талбайг хариуцан хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах чиглэлээр ажиллаж байна. Нөхөрлөлүүдийг чадваржуулах, бэхжүүлэх, ойг нөхөн сэргээж, хамгаалах ажлыг сайжруулах тал дээр анхаарал тавьж, Ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын хүрээнд сумын хэмжээнд ойн 15 нөхөрлөлүүд, 10 ААНэгж нийт 30 га талбайд 60000 ширхэг шинэсний тарьцаар ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ойжуулалтын ажилд нийт 230 гаруй хүн оролцсон. Ойжуулалтын зардалд аж ахуйн нэгж, ойн нөхөрлөл улсын болон өөрийн хөрөнгө нийт 21.935.600 төгрөг зарцуулсан байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
Дундаж үнэлгээ				100%	
Дөрөв. Сангийн сайд					
4.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол					
27.	46.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2009.04.01 дугаар 93 1.Тендерийн урилга, үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд /www.tender.gov.mn/ цаг хугацаанд нь бүрэн тавьж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг нээлттэй, ил тод мэдээлж байх	2021 онд Худалдан авах ажиллагааны журмын дагуу дараахь тендерүүдийг зарлахаар төлөвлөсөн. Үүнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нийгмийн халамжийн сангаас зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендер /Нээлттэй/, 1-р Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендер /нээлттэй/, 2-р Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендер /нээлттэй/, ЭМТөвийн хэвтэн эмчлүүлэгчдийн хоолны материал нийлүүлэх тендер /Харьцуулалтын арга/, ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоол нийлүүлэх тендер /Нээлттэй/, Үдийн цай нийлүүлэх тендер /Нээлттэй/ зэрэг 6, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ЗДТГазарт шатахуун нийлүүлэх тендер /Харьцуулалт/, 2-р багт Өвсний фонд агуулах барих /Харьцуулалт/, Цагдаагийн тасагт авто машин худалдан авах /Харьцуулалт/, ЗДТГ-т авто тээврийн хэрэгсэл	Бүрэн хэрэгжсэн 100%	

		худалдан авах /Харьцуулалт/, ЗДТГ-ын барилга барих /Нээлттэй/ тендер нийт 5, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 8 төсөл, арга хэмжээ нийт 19 тендер, төсөл арга хэмжээг цахимаар зохион байгуулах төлөвлөгөөтэйгөөс ЗДТГ-ын барилга барих /Нээлттэй/ тендер, ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Рамын дэнж, найман буланд үерийн далантай болох /Нээлттэй/ тендерээс бусад 17 тендерийг зарлаж, зохион байгуулсан. Тендерийн урилга болон зарыг өдөр тутмын сонинд /нээлттэй тендер/, www.tender.gov.mn цахим хуудсанд болон ЗДТГ-ын Bat-Ulzii.ov.gov.mn сайтад мэдээлсэн ба тендерийн үр дүнг тухай бүр нийтэлж ажилласан.		
47.	2. Захиалагч бүр жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аливаа хяналт, аудитын тайлан, дүгнэлт, иргэд болон байгууллагаас гаргасан гомдлын тоо, агуулга, шийдвэрлэсэн байдлын талаар байгууллагын самбарт нийтэлж, нийтэд ил тод хүргэж байх	Тухайн онд Улс, орон нутгийн төсөв, ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалт, төлөвлөгөөг сумын ИТХурлын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 3/14 дугаар тогтоолоор батлуулсан. Төлөвлөсөн ажлын жагсаалтыг иргэдэд нээлттэй мэдээлж, Худалдан авах ажиллагааны tender.gov.mn , bat-ulzii.ov.gov.mn цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан. 2020 онд Улсын болон орон нутгийн хөрөнгө, ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, бичиг баримтын бүрдүүлэлтэд Аудитын газар хяналт, шалгалт хийж зөрчил, дутагдал гаргаагүй. Аудитын дүгнэлтийг сумын ИТХ-д тайлагнасан бөгөөд цахим хаяг, мэдээллийн самбарт мэдээлснээр иргэд тендер шалгаруулалтын үр дүнгийн гүйцэтгэлийн талаар мэдээлэлтэй болсон.	Бүрэн хэрэгжсэн 100%	
48.	5. Захилагч бүр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд засаан захиалагчийн эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллан, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай бүрт мөн хуулийн 49.2-т заасан баримт бичиг, материалыг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалж байх	Улс, орон нутгийн төсөв болон ОНХСангийн хөрөнгөөр 2020 онд хийгдсэн төсөл, арга хэмжээний тендерийн бичиг баримт, материалыг бүрэн бүрдүүлж, цэгцлэн үдэж, ЗДТГ-ын архивын нэгж болгон хадгалсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	

28.	49.	<p>Журам шинэчлэн батлах тухай /Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам/ 2016.01.11 дугаар 29</p> <p>2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.</p>	<p>Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Сумын Төсвийн ерөнхийлөн захирагч-1, Төсвийн байгууллагууд – 7 /ИТХ, ЗДТГ, ЕБС, 1-р Цэцэрлэг, 2-р Цэцэрлэг, ЭМТөв, Соёлын төв/ төсвийн мэдээллийг цахим хуудсаар нийтэд мэдээлэн ажиллаж байна. Хуулийн дагуу нийтэд ил тод байх нийт 30 төрлийн мэдээллээс өөр өөрийн цахим хуудсанд тохирох мэдээллийг журмаар тогтоосон хугацаанд үнэн зөв оруулж, заалт бүр дээр анхааран журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд шилэн дансны мэдээлэл хоцроосон асуудал гаргаагүй ажилласан. Шилэн дансны мэдээлэлд Санхүү хяналт аудитын албанаас улирал бүр хяналт шалгалт хийсэн бөгөөд аудитын хариу тайланг хугацаанд нь хүргүүлсэн.</p>	Бүрэн хэрэгжсэн 100%	
29.	50.	<p>Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2016.01.04 дугаар 15</p> <p>1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай:</p> <p>1.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллан, татварын нэгдсэн системд холбогдох;</p> <p>1.2. бараа, ажил, үйлчилгээг худалдан авах болон борлуулах тухай бүрт төлбөрийн баримт хэрэглэж, үүнийг хэвшүүлэх;</p> <p>1.3. иргэд, хуулийн этгээдэд төлбөрийн баримт хэрэглэх үйл ажиллагааг хэвшүүлэх талаар нийтэд сурталчлан таниулах.</p>	<p>Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, суманд үйл ажиллагаа явуулж буй 7 төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, дэлгүүр, үйлчилгээний 38 газар татварын нэгдсэн системд холбогдож, төлбөрийн баримт хэвлэж байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн сургалт, сурталчилгааг 1 удаа зохион байгуулж, 320 иргэн хамрагдаж, нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн талаар мэдээлэлтэй болсон. Худалдаа үйлчилгээ эрхлэгч 20 хүнд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх төлбөрийн баримт хэрэглэх тухай хугацаатай мэдэгдэл, шаардлагыг хүргүүлж ажилласан.</p>	Хэрэгжих шатанд 70%	
30.	51.	Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Засгын газрын 2021 оны 43 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 03 сарын 09-ны 1/139 дүгээр		

	<p>2021.02.17 дугаар 43</p> <p>1. Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай:</p> <p>1.1. үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;</p>	<p>албан тоотыг байгууллагын удирдлагуудад хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна. Энэхүү тогтоолын хүрээнд 3 сараас эхлэн гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардлыг өмнөх оны тарифаар тооцон олгож байна.</p> <p>Багаж техник, хэрэгсэл, тавилга, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, урсгал засварын зардлыг 100 хувиар, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, интернэтийн төлбөр, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчийг устгах, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуй эд зүйлийн зардлыг 50 хувиар хязгаарласны дагуу зардлыг төлөвлөн 03 сараас 08 сар хүртэл хэмнэн ажилласан бөгөөд 09 сард зарцуулах эрх үүссэн тул 2021 оны батлагдсан төсвийн төлөвлөгөөний дагуу зарцуулсан.</p>	<p>Бүрэн хэрэгжсэн 100%</p>	
52.	<p>1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх;</p>	<p>Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, орон тоог нэмэгдээгүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтан эхний хагас жилд байхгүй, нөхөн томилгоо хийсэн байгууллага байхгүй.</p>	<p>Бүрэн хэрэгжсэн 100%</p>	
53.	<p>1.3. төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь</p>	<p>Төсөвт байгууллагуудын албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлээгүй, шагнал, урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал авах гэсэн зардлууд гараагүй.</p>	<p>Бүрэн хэрэгжсэн 100%</p>	

	уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;			
54.	1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;	Энэ тогтоол батлагдснаас хойш Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулаагүй.	Бүрэн хэрэгжсэн 100%	
55.	1.5. салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;	Байгууллага бүр сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэж ажилласан. Төлөвлөгөө 6.2 сая төгрөг, гүйцэтгэл 6.0 сая төгрөг зарцуулсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
56.	1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;	Төрийн байгууллагууд баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулаагүй.	Бүрэн хэрэгжсэн 100%	
57.	1.7. хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай	Төсөвт байгууллагууд 2021 оны хагас жилийн байдлаар байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлээгүй.	Бүрэн хэрэгжсэн 100%	

		холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх;			
	58.	1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах;	Төсөвт байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төлөвлөгөө 256.0 сая төг, гүйцэтгэл 238.3 сая төгрөг зарцуулж, 20 хувь хэмнэсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%	
	59.	1.9. бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах.	бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг 50 хувь бууруулж ажиллаж байна. Төлөвлөгөө 5.1 сая төгрөг, гүйцэтгэл 4.2 сая төгрөг зарцуулсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
31.	60.	Босго үнэ шинэчлэн батлах тухай 2021.05.05 дугаар 124 2. Энэ тогтоолоор баталсан босго үнийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөн ажиллахыг бүх шатны Төсвийн ерөнхийлөн захирагч нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	Засгийн газрын 2021 оны 05 сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг энэ тогтоол гарснаас хойшхи бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
4.2 Сайдын тушаал					
32.	61.	Журам шинэчлэн батлах тухай 2021.04.20 дугаар 61 1. “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай. 2. Шинэчлэн баталсан журмыг мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.	Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын шинэчилсэн журмыг мөрдөж, сумын Засаг даргын шийдвэрээр Засаг даргын нөөц сангаас 2021 онд 79 150 000 төгрөгийн зардлыг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн зориулалтын дагуу зарцуулж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
33.	62.	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам 2021.05.24 дугаар 86 1.“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны шинэчилсэн журмыг хяналтад авч, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд оролцдог бүх шатны албан хаагчдад таниулан ажилласан. Мөн ЗДТГ-ын Санхүүгийн албанаас “Худалдан авах ажиллагаа” нэртэй	Бүрэн хэрэгжсэн 100%	

		2.Батлагдсан журмыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлж, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд мөрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Төрийн сангийн газар /М.Батхуяг/-т тус тус үүрэг болгосугай.	групп чат нээж, үүнд шинэчилсэн дүрэм, журам, заавар, зөвлөгөөг тогтмол өгч хэрэгжүүлэн ажиллаж байна.		
Дундаж үнэлгээ				94,7%	
Тав. Хууль зүйн, дотоод хэргийн сайд					
5.1 Ерөнхийлөгчийн зарлиг					
34.	63.	Монгол Улсын Төрийн тугийг хүндэтгэх тухай 2017.06.16 Дугаар 136 1.Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг гүнээ дээдлэн хүндэтгэж байхыг иргэдэд уриалсугай. 2.Есөн хөлт Их цагаан тугийг дууриалган үйлдсэнийг төр, олон нийтийн аливаа үйл ажиллагаанд ашиглахгүй байхыг төрийн захиргаа, нутгийн өөрөө удирдах болон холбогдох бусад байгууллагад даалгасугай. 3.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль болон холбогдох бусад журмыг дагаж мөрдөх, биелэлтэд хяналт тавихыг бүх шатны Засаг даргад үүрэг болгосугай.	Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг гүнээ дээдлэн хүндэтгэж байх талаар албан газар, аж ахуйн нэгж, иргэдэд хандан уриалга гаргасан. Төрийн байгууллагууд төрийн тугийг хүндлэн Есөн хөлт Их цагаан тугийг дууриалган үйлдсэнийг төр, олон нийтийн аливаа үйл ажиллагаанд ашиглахыг зогсоож, төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль болон холбогдох бусад журмыг дагаж мөрдөн, биелэлтэд тооцон ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
5.2 Монгол Улсын Засгийн газрын тогтоол					
35.	64.	Байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг шуурхай болгохтой холбогдсон зарим арга хэмжээний тухай 2007.05.03 дугаар08 1.Байгууллага иргэдээс ирүүлсэн болон дээд шатны байгууллагаас шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн албан бичиг хүсэлтийг тухайн асуудлыг хариуцсан ажилтанд шуурхай хүргэж	Байгууллага, иргэдээс болон дээд шатны байгууллагаас шийдвэрлүүлэхээр ирүүлсэн албан бичгийг ЗДТГ-ын архив, бичиг хэргийн эрхлэгч хариуцан бүртгэж тайлант хугацаанд 132 албан бичгийг бүртгэн, холбогдох ажилтанд шуурхай хүргэж, хариутай 60 албан бичгийг хугацаанд хүргэсэн. ЗДТГазраас өөр байгууллага, албан тушаалтанд нийт 264 албан бичиг бүртгэн шилжүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%	

		хууль тогтоомжинд заасан хугацаанд хариу өгч байх			
36.	65.	Сургалт, семинарын зохион байгуулалтыг сайжруулах тухай 2008.11.12 дугаар 32 3.а Сургалт, семинарын нэгдсэн хуваарийн биелэлтэд байнгын хяналт тавьж, төлөвлөгдсөн арга хэмжээнд ажилтнуудаа оролцуулан, тэдгээрийн томилолтын тайлан, үр дүнг тогтмол дүгнэж байх.	Коронавирусын нөхцөл байдалтай уялдуулан сургалтын 80 хувь нь цахимаар зохион байгуулагдсан. 2021 онд 90 чиглэлээр 66 удаа цахимаар, 24 удаа танхимаар давхардсан тоогоор 397 албан хаагч өөрийн ажлын чиглэлээр сургалтанд хамрагдаж мэдлэг, чадвараа дээшлүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%	
37.	66.	Журам батлах тухай 2017.07.04 Дугаар 195 2. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх тусгай дансыг Сангийн яамнаас тогтоосон журмын дагуу нээж, ашиглах арга хэмжээ авахыг эрх бүхий байгууллагын дарга нарт даалгасугай.	Сумын Засаг даргын захирамжаар Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, үнэлэх, худалдан борлуулах, устгалын 3 комисс ажилладаг. Хураан авсан эд зүйл бүртгэгдээгүй. Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх тусгай дансыг Сангийн яамнаас тогтоосон журмын дагуу нээсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%	
Дундаж үнэлгээ				98,2%	
Зургаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд					
6.1 Монгол Улсын Их Хурлын тогтоол					
38.	67.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай. 2013.02.07 дугаар 20 б/аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны ажилтны тоог тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны тоо, ажлын байран дахь эрсдэлийн түвшнээс хамааруулан тогтоох, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл болон мэргэжлийн холбоотой хамтран ажиллах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах;	2021 оны 04 дүгээр сарын 01-30-ны хооронд “Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулья ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлбэ” уриан дор Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулсан. Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хямралыг даван туулах хариу арга хэмжээ авах талаар цахимаар, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан. Хүнсний дэлгүүрүүдэд хяналт тавьж халвараас сэргийлэх зөвлөмж тараасан. Аяны хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын талаар Facebook group, цахим орчин, мэдээллийн хэрэгслүүдээр тухай бүр нь сурталчилсан. Сурталчилгаанд 250 гаруй иргэн хамрагдсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
6.2 Монгол Улсын Засгийн газрын тогтоол					
39.	68.	Шалгуур үзүүлэлт батлах тухай 2012.01.18 дугаар 15	Хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийн 4 бүлгийн 38 шалгуур үзүүлэлтийн дагуу		

		2.Шалгуур үзүүлэлтийн мэдээллийг жил бүрийн I улиралд багтаан мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж, харьцуулсан дүн шинжилгээ хийж ажиллахыг ЗГ-ын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	холбогдох тоон мэдээллийг нэгдсэн санд шинэчлэн оруулж, хүүхдийн эрхийн байдалд дүн шинжилгээ хийж, тайлан мэдээг гаргасан. Сумын хэмжээнд 0-17 насны 2848 хүүхэд, 2021 онд 117 хүүхэд төрсөн. Дотуур байранд 81 хүүхэд амьдарч байгаа бөгөөд ЕБС-д 1681 суралцагч сургуульд хамрагдан нийт 58 бүлэг хичээллэж байна. Цэцэрлэгт 472 хүүхэд хүмүүжиж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны тэтгэмж авдаг хүүхэд 32 хүүхэд, хүүхдийн оролцооны байгууллагын тоо 10, Хүүхэдтэй холбоотой гарсан шийдвэр 2, хүүхэдтэй холбоотой гэмт хэрэг гараагүй. Хүүхдийн эндэглэл 1, дугуйлан секцэнд 1250 сурагч хамрагддаг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгаалал, аюулгүй орчин, хүүхэд хүмүүжүүлэх зөвлөмж, гарын авлага, мэдээлэл, шторк зэргийг Бат-Өлзий сумын нэгдсэн групп, Урьдчилан сэргийлэх группээр нийтэлж сурталчилсан. Хүчирхийлэл үйлдэгч нар болон хүчирхийлэлд өртөгч нийт 31 иргэнд сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөөг өгч ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
40.	69.	Конвенцийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай. 2013.08.02 дугаар 281 2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, иргэний нийгмийн оролцоотойгоор салбар, орон нутгийнхаа түвшинд хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Энэ ажлын хүрээнд 2021 онд Хөгжлийн бэрхшээлтэй 250 иргэнийг үнэмлэхжүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулсан. Судалгааг шинэчлэн гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. ХБИргэдэд шаардлагатай тусламж, дэмжлэгийг хууль, журмын дагуу олгож байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
41.	70.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2016.05.02 дугаар 234 2. Монголын улаан загалмай нийгэмлэгээр Засгийн газар, нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх үйл ажиллагааг	Бат-Өлзий сумын анхан шатны Улаанзагалмайн хороо 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж үйл ажиллагаа жигдэрсэн. МУЗН-ийн гишүүд татвараа жил бүр төлж хэвшсэн. 2021 онд 2.0 сая.төгрөг дансанд төвлөрүүлж, улаан загалмайн татварын төлөвлөгөө биелүүлсэн. 2021 оны 1 дүгээр сарын 15-нд Монголын улаан	Бүрэн хэрэгжсэн 100%	

		<p>удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий зөвлөлийг үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулан ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, аймаг, дүүргийн Засаг дарга нарт, зөвлөлийн ажиллах журмыг баталж мөрдүүлэхийг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатарт тус тус даалгасугай.</p> <p>3. Хүмүүнлэгийн чиглэлээрх Засгийн газрын зарим чиг үүргийг Монголын улаан загалмай нийгэмлэг гүйцэтгэх болсонтой холбогдуулан тус нийгэмлэгт төсвөөс олгох санхүүжилтийг 2017 оноос эхлэн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, Сангийн сайд Б.Болор, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>загалмайн нийгэмлэг, Олон улсын улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн дэмжлэгтэй Бат-Өлзий сумын амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, зуданд нэрвэгдсэн 15 малчин өрхөд тус бүр 240 000 төгрөг, малын эрдсийн багцын буцалтгүй тусламж үзүүлсэн.</p> <p>Мөн сумын ИТХурлаас 150л шатахуун гаргаж отроор өвөлжиж байгаа 7 өрхөд ИТХ-ын төлөөлөгчдийн дэмжлэгээр 78000 төгрөгийн хүнс, ахуйн хэрэгцээний багц, хурлын төлөөлөгч Х.Нямлхагвын зүгээс 7 тн нүүрсний тусламж үзүүлсэн.</p> <p>Аймгийн Улаанзагалмайн хорооноос 2021 оны 5 сард 15 айлд хүнсний тусламж үзүүлсэн. Тус сумын иргэн Л.Дуламсүрэн өндөр настай 2 айлд хос дээл, 15 айлд малын нэмнээ хийж өгч тусламж хүргэсэн. Мөн М.Ганчимэг 1-р багийн өндөр настан 1 иргэнд дээл, 1 өрхийн 2 хүүхдэд дээл, 3 айлын 9 хүүхдэд хүүхдийн баяраар бэлэг өгч тусламж дэмжлэг үзүүлсэн.</p> <p>2021 оны 11-р сард үер усны аюулд өртсөн 9 өрх тус бүрт 370,0 мянган төгрөг, хөнжил, гудас, ариун цэврийн багцыг олгосон.</p>		
42.	71.	<p>Насны хишиг олгох журам батлах тухай 2017.01.25 дугаар 31</p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын дагуу ахмад настанд насны хишиг олгох ажлыг 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг ХНХ-ын сайд Н.Номтойбаярт үүрэг болгосугай.</p>	<p>Насны хишгийн мөнгийг 2021 онд 65-69 насны 109 ахмад настанд 10550.0 мян.төг, 70-79 насны 101 ахмад настанд 15840.0 мян.төг, 80-89 насны 33 ахмад настанд 9600.0 мян.төг, 90-с дээш насны 3 ахмад настанд 1500.0 мян.төг, нийт 246 ахмад настанд 37490.0 мян.төгрөгийг бүрэн олгосон.</p>	Бүрэн хэрэгжсэн 100%	
43.	72.	<p>Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2019.01.30 дугаар 57</p> <p>1. Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.</p>	<p>Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт тогтоосон хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулаагүй болно. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлж, холбогдох хүмүүст мэдэгдэл хүргүүлсэн.</p>	Бүрэн хэрэгжсэн 100%	

		3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.			
44.	73.	Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2019.03.21 дугаар 111 2. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.	2021 онд 25-аас дээш ажилтантай 3 байгууллагын судалгааг шинэчлэн гаргаж, эдгээр байгууллагуудаас Ерөнхий боловсролын сургууль, СӨББ нэгдүгээр цэцэрлэг заасан квотод тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж байна. Эрүүл мэндийн төвийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2021 оны 6 дугаар сараас хасагдаж Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажлуулаагүй орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө.	Бүрэн хэрэгжсэн 100%	
45.	74.	Журам шинэчлэн батлах тухай 2021.01.06 дугаар 05 3. Малын тоог бэлчээрийн даацад тохируулан бэлчээрийг зохистой ашигласан, малын чанарыг сайжруулж нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлсэн, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа бүрэн хамруулсан, эрүүл чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, тэдний нийгэмд оруулж байгаа хувь нэмэр зэрэг шалгуур үзүүлэлтээр орон нутагтаа тэргүүлсэн малчин өрх, саальчин, фермерийг шалгаруулан шагнан урамшуулж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	2021 онд Журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж 2 дугаар багийн малчин өрх Ч.Дашлхагва, Улсын хошой аварга малчин өрхөөр Д.Суурь, Т.Эрдэнэбат нарыг, Улсын аварга саальчинд 4 дүгээр багийн иргэн Д.Тогоог тодорхойлж холбогдох газарт уламжилсан. Үүнээс 4 дүгээр багийн иргэн Д.Тогтоо болзол, журмыг хангаж Улсын аварга саальчинаар шалгарч, шагналаа гардан авсан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
46.	75.	“Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” батлах тухай 2021.03.10 дугаар 58	Энэхүү төсөл нь залууст эртэч, амьдралын идэвхтэй хэв маяг, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх хэлбэрээр ажилтай, орлоготой болоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ хүрээнд өөрийгөө танин мэдэх,	Бүрэн хэрэгжсэн 100%	

		3. Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай.	зөв дадал хэвшил, харилцаа хандлага, эх оронч үзэл санааг суулгуулж, бие бялдрын зөв хүмүүжил, гэр бүлийн эерэг харилцаа, соёл төлөвшүүлэхэд чиглэсэн багц сургалтыг 18-34 насны ажил хийх амьдралаа өөрчлөх хүсэлтэй эрэгтэй, эмэгтэй залуучуудыг сар бүр сонгон шалгаруулж нэг сая төгрөгийн тэтгэлэгтэй, нэг сарын хугацаатай сургалт явуулсан. Энэ сургалтад манай сумаас эрэгтэй, эмэгтэй 2 залуу сургалтад хамрагдаж амжилттай төгссөн.		
Дундаж үнэлгээ				100%	
Долоо. Батлан хамгаалахын сайд					
7.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол					
47.	76.	Журам батлах тухай /Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам/ 2017.05.17 дугаар 144 2. журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг МУ-ын Шадар сайд У.Хүрэлсүх, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	2021 оны ээлжит цэрэг татлагаар 255 цэргийн насны эрчүүд татагдаж, эрүүл мэнд, бие бялдараар 22 хүн тэнцэж, хилийн цэргийн 0131 дүгээр ангид 8 цэрэг, 167 дугаар ангид 5 цэрэг, 256 дугаар ангид 9 цэрэг тус тус татагдсан. Цэргийн насны иргэдээс эрүүл мэндийн шалтгаанаар 94 иргэн тэнцээгүй. Эрүүл мэндийн төвд эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийг эмчлэн эрүүлжүүлж, хэрэгжүүлсэн ажлын тайланг аймгийн Цэргийн штабд хүргүүлэхийг даалгасан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
48.	77.	Мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай. 2021.02.17 дугаар 41 1. Цэргийн дүйцүүлэх албыг 2021 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 6,350,895 (зургаан сая гурван зуун тавин мянга найман зуун ерэн таван) төгрөг байхаар тогтоосугай. 2. Цэргийн дүйцүүлэх албыг хаалгах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2021 онд 42 иргэнтэй мөнгөн төлбөрийн тооцоо хийж дууссан, мөнгөн төлбөрийн төлбөр төлөх иргэн гараагүй.	Бүрэн хэрэгжсэн 100%	

49.	78.	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2021.07.28 дугаар 220 2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Дүйцүүлэх албанаас 2021 онд 3 цэрэг халж, 2021 онд цэргийн дүйцүүлэх албанд 3 цэрэг алба хааж, 2021 оны 9, 10 сард сургалтад 30 хоног хамрагдаж, Хархорин суманд цэргийн бэлтгэл 14 хоног, 16 хоног ногоон тэжээл хураасан.	Бүрэн хэрэгжсэн 100%	
Дундаж үнэлгээ				100%	
Найм. Боловсрол, Соёл, шинжлэх ухааны сайд					
8.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол					
50.	79.	“Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед нүүлгэн шилжүүлэх журам батлах тухай 2016.05.31 №288 2. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед улсын болон орон нутгийн номын санг нүүлгэн шилжүүлэх ажлын бэлтгэлийг сайтар хангуулж, хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед Соёлын төвийн номын санг нүүлгэн шилжүүлэх ажлын бэлтгэлийг сайтар хангаж, журмыг мөрдөж ажиллах үүрэг чиглэл өгч, хяналт тавин ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
51.	80.	Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай 2013.02.02 дугаар 37 4. Төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартыг бүх шатанд мөрдлөг болгож төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авахыг ЗГ-ын гишүүн, ЗГ-ын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. 5. Хот, суурин газрын төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагын хаяг, зар сурталчилгааг монгол кирил бичгээр бичиж байхыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Шинэчлэн батлагдсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар” сэдвээр 6 байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан 6 албан хаагчдад мэдээлэл өгсөн. Хувийн хэвшлийн байгууллагуудад хаяг, зар сурталчилгааг Монгол кирил бичгээр бичиж байхыг анхааруулж албан тоот хүргүүлэн хяналт тавин хэрэгжүүлэн ажиллаж байна. “Үндэсний бичиг III” хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, уран зохиолын 8 багш 5 байгууллагын 150 албан хаагчид үндэсний бичгийн хичээл зааж зохих мэдлэгийг эзэмшүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%	
52.	81.	Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого батлах тухай 2019.04.17 дугаар 153	2021 оны 10 дугаар сар хүртэлх Коронавирусийн халдвараас шалтгаалан ямар нэгэн спортын уралдаан, тэмцээн зохион байгуулаагүй. Биеийн тамир, спортыг	Хэрэгжих шатанд 70%	

		<p>3. “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, улс, орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>хөгжүүлэхээр 2021 оны 12 дугаар сарын 04, 05-нд "Kharakhorum ice festival-2021" мөсөнд авиралтын цомын аварга шалгаруулах тэмцээн Бат-Өлзий сумын Улаанцутгалантад амжилттай зохиогдож өндөрлөсөн. Экстрим спорт сонирхогчид 2012 оноос эхлэн тус тэмцээнийг зохион байгуулж ирсэн ч сүүлийн хоёр жилд ковидын улмаас тасраад байсан. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, мөсөнд авиралтын шилдэг тамирчдыг төрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой учраас зохион байгуулагч “Монголиа Экспедишнс” ХХК-тай хамтран ажиллаж байна. Энэ удаагийн тэмцээнд 12 байгууллага, клубын 70 тамирчин оролцож, хоёр өдрийн турш хурд хүч, авхаалж самбаагаа сорин мөсний авиралт хийсэн. Энэхүү тэмцээнийг нийт 500 гаруй хүн ирж үзэж, сонирхсон.</p>		
53.	82.	<p>Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай 2020.12.23 Дугаар 235</p> <p>4. Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөө, анги танхимыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагч ашиглах боломжтой стандарттай байхаар тоноглож, тохижуулах цогц арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх зайлшгүй шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүний зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан шийдвэрлэж байхыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p> <p>6. Бүх шатны сургалтын байгууллагын орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан зохих</p>	<p>Ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах нийгмийн ажилтнаар ахлуулсан “Дэмжлэг баг” байгуулан ажиллаж байна. 1-5 дугаар ангийн 5 сурагчийг багш тус бүр нь ганцаарчилсан хөтөлбөрөөр сургаж байгаа. Ганцаарчилсан хөтөлбөрөөр сургаж байгаа багш нарт урамшуулал олгуулах санхүүжилтыг төсөвт тусгуулах БСУГазарт хүсэлт хүргүүлсэн. Мөн унших бэрхшээлтэй сурагчдад уншуулах зорилгоор Сурагчдын зохиосон “Банхарын адал явдал” 15 цуврал 3D болон сонсдог ном хийсэн. Цаашид “Зохиолч” клубийг чиглүүлэн ажиллаж, судалгаагаа үргэлжлүүлж байна. Хичээлийн 2 дугаар байрны гадна хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зориулсан налуу стандартын орж, гарах шаттай болсон.</p>	Хэрэгжих шатанд 70%	

		стандартад нийцүүлсэн зам, талбайтай болгох арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.			
54.	83.	<p>Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2021.02.24 дугаар47</p> <p>3. Эрсдэлгүй ногоон бүсэд танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэхтэй холбогдуулан төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрыг зохих журам, зааврын дагуу ариутгаж халдваргүйжүүлэхэд нэн шаардлагатай ариутгалын бодис, багаж, хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p> <p>4. Энэ тогтоолын 2, 3-т заасан арга хэмжээнд шаардагдах зардлыг тооцож, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны батлагдсан төсвийн багцын хүрээнд зохицуулалт хийж, санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>ЕБС-ийн танхимын хичээл эхлэхэд, анги танхимд цэвэрлэгээ хийж ариутгал, халдваргүйжүүлэлт хийж сургалтын үйл ажиллагааг эхлүүлсэн. Цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт хийхдээ чанарын баталгаатай, хэрэглэх заавар нь батлагдсан халдваргүйтгэлийн бодис жавьелин, хлормин хэрэглэсэн. Нэг ширээнд нэг сурагч суухаар ширээ хоорондын зайг 1.5-2 метр байхаар байрлуулж нэг ангид 6-8 сурагчаас илүү хүн оруулахгүй зохицуулж ЭМЯ болон мэргэжлийн байгууллагуудаас гаргасан санамж, зөвлөгөө, зай барих тэмдэглэгээг цаг тухай бүрт сургуулийн коридор, гадна талбай, анги танхимд байршуулсан.</p> <p>Багш, ажилчид, суралцагчдыг эрүүл мэндэд хяналт, тандалт хийж биеийн халууныг цаг тухай бүрт үзэж, Багш, ажилчид, суралцагчдын халуун хэмжигч, гар ариутгах нөхцөлөөр хангаж гар халдваргүйжүүлэгч уусмалыг хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулсан. Багш ажилагсад “Covid-19”-ын вакцины 1, 2 дугаар тунд 100 хувь хамрагдсан. 3 дугаар тунд 40 хувь нь хамрагдсан. Сайдын тушаалаар баталсан “Түр журам”-ыг мөрдөж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.</p>	Хэрэгжих шатанд 70%	
Дундаж үнэлгээ				82%	
Ес. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд					
9.1 Засгийн газрын тогтоол					

55.	84.	<p>“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам 2017.05.24. дугаар 151</p> <p>4. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг сурталчлан хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогт нарт, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд, журмыг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тогтоолыг хяналтад авч, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг сумын цахим хуудсаар иргэдэд сурталчилсан. Сурталчилгаанд 250 иргэн хамрагдсан.</p>	<p>Бүрэн хэрэгжсэн 100%</p>	
		Дундаж үнэлгээ		100%	
Арав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд					
10.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол					
56.	85.	<p>Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, 2016.03.14 дугаар 153</p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор тогтоосон товын дагуу төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж, Сум хөгжүүлэх сангаас 2021 онд 12 иргэнд 49.0 сая төгрөгийн зээл олгосон. Сум хөгжүүлэх сангийн зээлэнд сар бүр хяналт тавьж зээлийн үлдэгдэлийг тулган, зээлийг гэрээний хугацаагаар төлж байхыг иргэдэд сануулан ажиллаж байна. Хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2021 оны 11 дүгээр сарын 19-нд зээлийн гэрээг зөрчин хугацаа хэтрүүлсэн зээлтэй байгаа өрхүүдээр явж, зээл төлүүлэх арга хэмжээг авч ажилласан.</p>	<p>Хэрэгжих шатанд 70%</p>	
57.	86.	<p>Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах тухай 2012.04.25 дугаар 137</p> <p>3. Хөдөө аж ахуйн ээлжит тооллого, судалгаа явуулахтай холбогдуулан харьяа нутаг дэвгэртээ тооллого явуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулж</p>	<p>Хагас жилийн мал тооллого зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн а/93 дугаар захирамжаар томилон 2021 оны 06 дугаар сарын 15-наас 06 дугаар сарын 22-ний хооронд зохион байгуулж, тооллогод 234 өрх хамрагдаж, программд тоон мэдээллийг бүрэн оруулсан. Мал тооллогын зардалд 1 335 742 төгрөг зарцуулав.</p>	<p>Бүрэн хэрэгжсэн 100%</p>	

		байгаа өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулах арга хэмжээ авч, тооллогын ажилд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.			
58.	87.	<p>Малчдын хоршоог хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай.</p> <p>2013.01.12 дугаар 08</p> <p>3.Хоршооны хөдөлмөрийн давуу тал, ач холбогдлыг орон нутагт сурталчлан хэрэгжүүлэх арга хэмжээг хоршооллын болон хоршоог дэмжигч бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>2021 оны 03 дугаар сарын 06-нд сумын ЗДТГазар, ХААТасаг, “Тогтвортой ноос ноолуур эвсэл” төрийн бус байгууллагатай хамтран ноолуур ялгах, ангилах мал маллагааны сургалтыг зохион байгуулж сургалтанд сумын удирдлага, мэргэжилтнүүд, Хамтын хүч хоршооны 18 эмэгтэй, нийт 21 хүн хамрагдсан.</p> <p>“Ногоон алт, малын эрүүл мэнд” төсөл Хамтын хүч хоршоо, ХААИС-ийн багш нар хамтарч 2021 оны 9-р сард лууль, халгай болон бусад ургамалаар дарш бэлтгэх япон аргыг зааж дадлагажуулах сургалтыг зохион байгуулан Хамтын хүч хоршооноос 14 хүн хамрагдаж даршийг бэлтгэж суралцсан.</p> <p>“Хангайн бүсийн” зөгийчдийн чуулга уулзалт 2021 оны 07-р сарын 29-нд Бат-Өлзий суманд зохион байгуулагдаж Монголын зөгийн холбооны удирдлага, гишүүд 3, Хар хорин сумаас 5, Хужирт сумаас 1, Бат-Өлзийт сумаас 8 хүн нийт 17 зөгийчин оролцож туршлага солилцон мэдлэг, чадавхийг нэмэгдүүлсэн сургалт болсон.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуйн газар, “Малчин” телевиз хамтран “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” зорилтот жилийн хүрээнд Бат-Өлзий сумын Хамтын хүч хоршооны үйл ажиллагаа мөн ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасагтай хамтран хөх савнаас татгалзаж зориулалтын хүнсний сав болон уламжлалт мод модон сав суулга хэрэглэх аяны хүрээнд хийгдсэн ажил, лууль, халгайгаар дарш бэлтгэх, хоршооны гишүүн О.Батсүрэнгийн зөгийн аж ахуй, Малчны аравтын бүлэгүүд өвөлжилтийн бэлтгэл ажил хангаж хадлан тэжээлийн бэлтгэл, “Хангайн бал” хоршооны зөгийн аж ахуй өсгөн үржүүлж зөгийн бал хэрхэн бэлтгэж буй талаар зураг авалтыг хийж</p>	Бүрэн хэрэгжсэн 100%	

			<p>нэвтрүүлэг бэлтгэн хүргэсэн. Богино хэмжээний 3 минутын бичлэгийг Бат-Өлзий зарын нэгдсэн хуудасаар 385 иргэнд хүргэн сайн туршлагыг сурталчлан таниулсан. "Нэг сум-Нэг хоршоо" хөдөлгөөн өрнүүлэх, малын гаралтай түүхий эдийн анхан шатны тордолт, хүнсний ногооны хадгалалт хамгаалалт хийх талаар сургалтыг ХХААГ, аймгийн ХАА-н хоршоологчдын холбоо, Бизнесийн шинэ санаа нэвтрүүлэх төв, Өрхийн тариалан бизнес хөгжил ТББ хамтран Хужирт суманд 2021 оны 11-р сарын 1-нд зохион байгуулж ХААТ-ийн мэргэжилтэн Н.Түвшин, малчдын Хамтын хүч хоршооноос Х.Алтанцэцэг, И.Дэлгэрбаяр, О.Батсүрэн, ногоочин н.Мягмарсүрэн, н.Гэрэлчимэг нар сургалтанд хамрагдсан.</p> <p>Малчид тариаланчдын зөвлөгөөнийг 2021 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж 60 малчин, тариаланч хамрагдан хоршооны шинэчилсэн найруулсан хуулийн талаар мэдээлэл хийж гарын авлага тараасан.</p> <p>Хоршоодын бизнесийн хөгжлийн түвшинг ахиулах, чадавхжуулах зорилгоор 2020 онд суманд үйл ажиллагаа явуулж байгаа 8 хоршоонд үнэлгээ хийснээс хөгжиж буй хоршоо-2, идвэхжиж буй хоршоо-3, идвэхгүй хоршоо-3 гэж үнэлэгдсэн. Хоршоодын бүртгэлийг жил бүр шинэчлэхээс гадна хоршоодын үйл ажиллагаа тогтмолжиж эзэмшлийн талбайдаа төмс, хүнсний ногоо тарих, мал аж ахуйгаа эрхлэн сүү цагаан идээ боловсруулах, зөгийн аж ахуй эрхлэх ажлыг зохион байгуулж, бүлээрээ хоршин хөдөлмөрлөж, өрхийн орлогоо нэмэгдүүлж 15 ажлын байраа хадгалагдаж бусдад үлгэрлэн ажиллаж байна.</p>		
59.	88.	<p>Хүнсний зориулалтын бус хуванцар савны талаар авах зарим арга хэмжээний тухай 2015.12.14 дугаар 496</p> <p>3. Хүнсний зориулалтын бус хуванцар савыг хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн газарт хоол,</p>	<p>"Хүнсний бус хуванцар сав, хуванцар савны хэрэглээ ба хор хөнөөл, хуванцар савны таних тэмдэг, хуванцар саван дахь чимээгүй хор" сэдвээр 206 гарын авлага, 2 видео хичээлийг цахимаар 5537 иргэнд 2, 3, 4-р улиралд албан байгууллага, цайны газрууд болон малчин өрх, айл өрхүүдээр тараан цахим хуудсаар иргэдэд хүргэсэн.</p>	Бүрэн хэрэгжсэн 100%	

		<p>хүнсний савлагаанд хэрэглэхийг хориглож, хэрэгжилтэд нь холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодтой хамтран хяналт тавьж ажиллан, энэ тухай нийтэд мэдээлэл, сэрэмжлүүлэг түгээж, сургалт, сурталчилгаа зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ш.Раднаасэд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>Танхимаар болон малчны хотонд 199 малчинд хуванцар савны хор хөнөөл хэрэглээний талаар мэдээллийг хүргэсэн. Хөх сав канистаргүй аяныг 3 дугаар улиралд “Хамтын хүч” хоршоотой хамтран 69 малчинд сурталчлан мэдээ мэдээлэл хүргэн гарын авлагаар хангасанаар 35 өрхийн 11 хувь буюу 4 өрх 100 хувь хөх савнаас татгалзаж үлдсэн 39 хувь буюу 13 өрх 50 хувь хөх саваа хүнсний зориулалтын саваар сольсон. Хүнсний зориулалтын савыг Хамтын хүч хоршоо Улаанбаатар хотоос малчдад нийлүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан. “Витафит милк” ХХК-аас харилцагч 15 малчинд 40 литрийн бидоныг өгч урамшуулсан. Цаашид бүх өрхүүдийг хуванцар савнаас татгалзаж, зориулалтын савыг ашигладаг болгох зорилт тавин ажиллаж байна. Байгууллага аж ахуйн нэгжүүд 100% хуванцар савнаас татгалзсан.</p>		
60.	89.	<p>Хөрс хамгаалах өдөртэй болох тухай 2017.05.24 дугаар 149</p> <p>1. Жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногийн Бямба гарагийг “Хөрс хамгаалах үндэсний өдөр” болгон тэмдэглэж байхаар тогтоосугай.</p> <p>2. “Хөрс хамгаалах үндэсний өдөр”-ийг уул уурхай, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөрс хамгаалах, түүнийг нөхөн сэргээх, хот, суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах, саармагжуулах талаар тухайн жилд зохион байгуулах ажил, арга хэмжээг төлөвлөж, тэдгээрийг олон нийтэд таниулан сурталчлах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран жил бүр зохион байгуулах замаар тэмдэглэн өнгөрүүлж байсугай.</p>	<p>“Хөрс хамгаалах үндэсний өдөр”-ийг тохиолдуулан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгж, худалдаа, үйлчилгээний газрууд, иргэд нийтийн эзэмшлийн зам талбай болон гудамж, хороолол, далан гуу жалга нийт 15 га талбайн хогийг цэвэрлэлээ. Хог цэвэрлэгээнд нийт 2.0 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Олон нийтийн сүлжээгээр “Хөрс хамгаалах үндэсний өдөр”-өөр хөрс хамгаалах, түүнийг нөхөн сэргээх, газрын хөрсний бохирдлыг бууруулахад иргэн бүр анхаарч, зохион байгуулж буй арга хэмжээнд оролцохыг уриалж, энэ талаар олон нийтэд мэдээлэл хүргэсэн.</p>	Бүрэн хэрэгжсэн 100%	

61.	90.	Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай 2019.05.01 дугаар 185 4. 2019 оны бэлчээр хамгааллын арга хэмжээг нийтийг хамарсан ажил болгон зохион байгуулах, цаашид жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоног болон 10 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба, Ням гарагийг “Бэлчээр хамгаалах өдөр” болгон зарлаж, мэрэгч амьтан, шавжны хөнөөлөөс бэлчээрээ хамгаалах бүх нийтийн арга хэмжээг сум, багийн түвшинд зохион байгуулж байхыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Бэлчээрийг зүй зохисой ашиглах, хамгаалах чиглэлээр малчид иргэдэд мэдээлэл, зөвлөгөөг өгч, жил бүр сумын Засаг даргын захирамжаар өвөлжөө, хаваржааны бэлчээрийг чөлөөлөх, өнжөөх, сэлгээх шийдвэрийг гаргаж, багийн Засаг дарга нар, иргэд мөрдөж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Сумын нутаг дэвсгэрийн бэлчээрийн хор хөнөөлын судалгаагаар бэлчээрийн мэрэгч амьтан, шавж илрээгүй.	Бүрэн хэрэгжсэн 100%	
62.	91.	Журам шинэчлэн батлах тухай 2019.09.04 дугаар 343 1. “Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.	2020 оны ноосны урамшуулал олгох ажлын хүрээнд суманд нийт 419 өрхийн 49771 кг ноосны 74,656,500 төгрөгийн урамшуулалыг малчид банкаар дамжуулан авсан. Данс болон нэр зөрүүтэй 4 малчны мэдээллийг засварлаж аймгийн ХААГазарт хүргүүлсэн.	Хэрэгжих шатанд 70%	
63.	92.	Журам батлах тухай 2020.03.25 Дугаар 113 1. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. (Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2020 оны 49, 251 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон) 2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42, 59 дүгээр тогтоолоор баталсан Хөдөө аж ахуй, Бизнесийн үйл ажиллагааг дэмжих 3 хувийн зээлийг ХААН болон Төрийн банкаар дамжуулан 103 малчинд малын тоо толгойг өсгөх, малын үүлдэр угсааг сайжруулахад 643200000 төгрөг, 117 бизнес эрхлэгчид үйл ажиллагаа хэвийн тогтвортой явуулах, эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх чиглэлээр 3122500000 төгрөгийг олгож 220 ажлын байр хадгалагдсан.	Хэрэгжих шатанд 70%	
64.	93.	Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2021.07.28 дугаар 221	Сумын Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 06-ны А/133 дугаар захирамжаар 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг 2 дугаар	Бүрэн хэрэгжсэн 100%	

	3. Өвөл, хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үед авах хариу арга хэмжээний талаар дор дурдсан ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: 3.1. Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө баталж, биелэлтэд хяналт тавих;	хавсралтаар, 2021 бэлтгэх хадлан тэжээлийн хуваарийг 3 дугаар хавсралтаар тус тус батлуулан хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн ирж өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөөд явсан.		
94.	3.2. Аймаг, сумын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийг тогтоож, хил заагийг тодорхойлон ашиглалт, хамгаалалтыг сайжруулан 2021-2022 оны өвөл, хаврын улиралд өөрийн аймаг, сумдын малыг оторлуулах;	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07дугаар сарын 08-ны 05/05 дугаар тогтоолоор 6 дугаар багийн Цагаан азарга орчмын 2202 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээний отрын бүс нутгаар шинэчлэн тогтоосон.	Бүрэн хэрэгжсэн 100%	
95.	3.3. Улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, төрийн холбогдох байгууллагын зөвшөөрлийн дагуу отроор өвөлжүүлж, хаваржуулах;	2021 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар өөрийн аймгийн өөр сумаас манай суманд оторлож ирсэн малчин өрх байхгүй байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
96.	3.4. Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах, говийн бүсийн болон хадлангийн нөөц багатай аймгуудад хадлан бэлтгэх талбайг гэрээгээр ашиглуулах, малчин, мал бүхий иргэнээр байгалийн хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэх, өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх;	Цаг хүндэрсэн үед өвс тэжээлээ нөөцлөх ажлын хүрээнд малчдын түвшинд нийт 2419 тн өвс, 806 тн гар тэжээл, 1613 тн хужир бэлтгэхийг багуудийн малчин өрхийн тоонд харьцуулан баг бүрт хувиарлан, бэлтгүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%	
97.	3.5. Бог малын тохироогоор дутагдаж байгаа хээлтүүлэгчийг нөхөн бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, малын чанар сайжруулахад анхаарах;	Оны эхэнд 632 бог малын хээлтүүлэгчтэй байсан ба 34 өсвөр хээлтүүлэгч бойжуулж, 164 хээлтүүлэгч худалдан авч малын чанарт анхаарч байна.	Хэрэгжих шатанд 70%	
98.	3.6. Малчдыг малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, гурил, тэжээлийн үйлдвэрүүдтэй харилцан бараа, бүтээгдэхүүн солилцох	Амьд мал болон түүхий эд бүтээгдэхүүнийг мөрдөн мөшгөх мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтэрч малчдад мал эмнэлгийн гэрчилгээний бичилт, баталгаажуулах	Бүрэн хэрэгжсэн 100%	

	(бартер), малаа зарж борлуулахад нь арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах;	ажлыг цаг алдалгүй зохион байгуулж системийн хэвийн үйл ажиллагааг ханган 327 гэрчилгээ бичиж амьд мал 3696 толгой /адуу-948, үхэр-1179, хонь-939, ямаа-630/, мах махан бүтээгдэхүүн 51560кг /адууны мах 830кг, үхрийн мах-48165кг, хонины мах-1550кг, ямааны мах-1015кг/, сүү сүүн бүтээгдэхүүн 144200кг /үхрийн аарц-141310кг, үхрийн өрөм 20кг, айраг-2500 кг, үхрийн ааруул 170кг, тараг-200/, арьс шир 2648 ширхэг /үхэр-648ш, хонь-1670ш, ямаа-330ш/ хонины ноос-38004кг, ямааны ноолуур 6,5 тн тус тус олгосон.		
99.	3.7. Үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арьс шир, ноолуурын түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх ажлын төлөвлөгөө, хуваарь гарган хэрэгжилтийг хангах;	Үндэсний үйлдвэрүүдт, ченж нартай аж ахуйн нэгжүүд хамтран ажиллах гэрээ байгуулж 2021 онд 6.5 тонн ноолуур тээвэрлэгдсэн тул гэрчилгээ олгож хянан баталгаажуулалтыг Мал эмнэлгийн тасаг хийн ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
100.	3.8. Отроор нүүдэллэж байгаа малчин өрхийг тухайн нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах;	2021 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар өөрийн аймгийн өөр сумаас манай суманд оторлож ирсэн малчин өрх байхгүй байна.		
101.	3.9. Бэлчээр дэх худаг, гар худаг болон инженерийн хийцтэй худгийг өөрийн хөрөнгөөр шинээр гаргасан иргэд, малчдын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, арга туршлагыг нийтийн хүртээл болгох;	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 4 дүгээр багийн Урд агуйтын Асгатад ОНХСангийн 18.0 сая төгрөгийн хөрөнгөөр, 1 дүгээр багийн Мухтагт Улсын төсвийн 25.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Баянговь-Ус” ХХК гүйцэтгэн инженерийн хийцтэй гүн өрөмний худгуудыг гаргаж, аймаг, сумын ажлын хэсэг хүлээн авсан. Мөн “Бэлчээрийн Удирдлага” төслөөс 2 дугаар багийн Баруун сөдтийн эх, Зүүнсөдтийн Хөшөөн талбайд гүн өрмийн худаг гарган ашиглаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
102.	3.10. Мал бордох аж ахуйг хөгжүүлэх, хүн амын хүнсний хэрэгцээнд стандартын шаардлага хангасан шинэ мах нийлүүлж байх арга хэмжээг авах;	Амьд мал болон түүхий эд бүтээгдэхүүнийг мөрдөн мөшгөх мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтэрч малчдад мал эмнэлгийн гэрчилгээний бичилт, баталгаажуулах ажлыг цаг алдалгүй зохион байгуулж системийн хэвийн үйл ажиллагааг ханган 327 гэрчилгээ бичиж амьд мал 3696 толгой /адуу-948, үхэр-1179, хонь-939, ямаа-630/, мах махан бүтээгдэхүүн 51560кг /адууны мах 830кг,	Бүрэн хэрэгжсэн 100%	

			үхрийн мах-48165кг, хонины мах-1550кг, ямааны мах-1015кг/-д гарал үүсэл тус тус олгосон байна.		
103.		3.11. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж, мал эмнэлгийн үйлчилгээний бэлэн байдал, шуурхай удирдлагаар хангаж ажиллах.	2020 оны жилийн эцсээр 1509 малчин, мал бүхий өрхийн 263432 мянган толгой мал тоолуулж, 2021 онд 54611 мянган толгой төл мал хүлээн авч, 1877 толгой мал үхэж хорогдсон мэдээтэй, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд улсын төсвийн санхүүжилттэй хоёр төрлийн вакцинд /боом/ 3.0 /галзуу/ 1.0 мянган толгой бод мал, орон нутгийн төсвийн санхүүжилттэй гурван төрлийн вакцинд /дотрын халдварт хордлого-28.0 бог, цусан халдварт-9.4 бод, дхх-энтеробактериозын хам-10.5/ буюу сумын дүнгээр 51.9 мянган толгой мал хамруулахаар МЭНС-д төлөвлөж мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бэлэн байдалын хангаж урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын гүйцэтгэл 100%-тай хийгдсэн байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
Дундаж үнэлгээ				93,6%	
Арван нэг. Эрүүл мэндийн сайд					
11.1 Монгол Улсын Засгийн газрын тогтоол					
65.	104.	Архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх талаарх төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх тухай 2008.06.11 дугаар 238 2. “Архидалт мансуурлын эсрэг ассоциаци” төрийн бус байгууллагыг сургалт, сурталчилгаа явуулах, цуглаан хийх байраар тухай бүр хангаж байхыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.	Суманд үйл ажиллагаа явуулж байгаа АА-н “Цагаан зам”, “Зөв зам” бүлэг, давхар хамаарлын Ал-аноны “Ариун сэтгэл”, “Аз жаргалын зам” бүлүүдийн уулзалт, цуглаан 2021 оны 10 дугаар сараас хойш хэвийн явагдсан. Сум, орон нутгийн зүгээс багийн төвийн байрны нэг өрөөг цуглаан хийх байраар хангаж өгсөн. Нийгэмд архины эсрэг эерэг зөв хандлагыг сурталчилсан мэдээ, мэдээллийг сумын 15 мянган хүнтэй группд тогтмол нийтэлж, түгээж байна.	Бүрэн хэрэгжсэн 100%	
66.	105.	Давсны хэрэглээг бууруулах үндэний стратеги батлах тухай 2015.08.31 дугаар 353 3. Үндэсний стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын	Эрүүл мэндийн төвөөс давсны хэрэглээг бууруулах 7 хоногийн удирдамж боловсруулан 2021 оны тэмдэглэлт өдрийг “Давс багатай ч илүү амттай” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100%	

		болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг ЭМССайд, Сангийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Энэ хүрээнд эмнэлгийн больницод хэвтэн эмчлүүлэгчдэд давсны зохистой хэрэглээний талаар сургалт зохион байгуулсан. Нийт 18 хүн хамрагдсан. Сумын төвд үйл ажиллагаа явуулдаг 3 хоолны газрын давсны хэрэглээнд хяналт хийж. Ажлын байранд зөвлөгөө сургалт өгсөн. Цайны газруудын өдөрт хэрэглэх давсны стандарт хэмжээ ДЭМБ-ын нормт хэмжээнээс 1 дахин өндөр байсан. Тиймээс цайгаа давсгүй чанаж үйлчилж байхыг сайтар зөвлөлөө. ЭМТөвийн цахим хуудсаар 2 төрлийн мэдээлэл, 1 төрлийн уриалга байршуулсан. Хандалтын тоо 367 байсан. Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратегийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээний судалгаанд Бат-Өлзий ЭМТ-ийн НЭМА хамрагдсан.		
67.	106.	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай 2017.01.18 дугаар 24 2. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэгт, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. 3. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусгаж гадаад улс, олон улсын байгууллагын зээл, хандив, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд	2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх, үзлэг шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаанд анхаарч ажиллаж байна. Сумын Эрүүл мэндийн төвд шаардлагатай боловсон хүчин, техник хэрэгсэлийг шат дараатай шийдвэрлэн одоогоор хүүхдийн эмч, эмэгтэйчүүдийн эмч, уламжлалтын нарийн мэргэжлийн эмч нарыг сургаж байна. 2020 онд дутагдалтай байсан Гематологийн анализатор төхөөрөмжтэй болж, цусны дэлгэрэнгүй шинжилгээг сумандаа хийж байна. Ковид-19 цар тахалын үеүүдэд сумын Засаг даргын нөөц сангаас Эрүүл мэндийн төвийн тусгаарлах эмнэлэг болон ажиглах байрны эмч, сувилагч нарт халад, малгай, нүүргэвч, бээлий авахад 242,5 мян.төгрөг, түргэн тусламжийн 2 автомашины засварын зардалд 6,286,5 мян.төгрөг, тусгаарлан ажиглах байранд хэвтэн эмчлүүлэгч нарын мах, хоол, хүнсний зардалд 13,812,450 төгрөг, ахуй хэрэглээний зардалд 1,918,950 төгрөг, хүчил төрөгчийн баллон /10л-ийн/ - 2 ш 1,000,0 төгрөг, ЭМТөвийн халаалтгүй өрөөг халаалттай болгох	Бүрэн хэрэгжсэн 100%	

	Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	засварт 500,0 төгрөг, тусгаарлах эмнэлэгт угаалгын машин 350,0 төгрөг, 1 иргэн 1 шинжилгээний 800 сорьцны үнэ 10,000,0 төгрөг, нийт 34,110,400 төгрөгийг санхүүжүүлэн шийдвэрлэсэн.		
Дундаж үнэлгээ			100%	
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ				96,5%

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД

БАТАЛГААЖУУЛСАН:
ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН